



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/252

Улаанбаатар хот

Гэрчилгээжүүлэх баг томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Иргэний нисэхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын 2016 оны “Final Mission Report to Civil Aviation Authority of Mongolia Technical Assistance” тайлангийн зөвлөмж, ИНД-139 “Аэродромын гэрчилгээжүүлэлт, үйл ажиллагаа” дүрмийн 139.5, 139.9 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ИНД-139 “Аэродромын гэрчилгээжүүлэлт, үйл ажиллагаа”-ийн хүрээнд гэрчилгээжих Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдаж буй Олон улсын шинэ нисэх буудлын аэродромыг гэрчилгээжүүлэх багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар томилсугай.


2. Гэрчилгээжүүлэх багийн ажиллах ажлын удирдамж, төлөвлөгөө болон зардлын төсвийг 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор батлуулахыг гэрчилгээжүүлэх багийн ахлагч Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтэс /С.Ерханат/-т, Гэрчилгээжүүлэлтийн ажилд дэмжлэг үзүүлж ажиллахыг Нисэх буудлуудын бодлого зохицуулалтын хэлтэс /Д.Эрдэнэбаатар/, Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Ё.Эрдэнэбат/-т, гэрчилгээжүүлэлтийн баг болон ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Дэд дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын алба /С.Манлай/-нд тус тус даалгасугай.

3. Гэрчилгээжүүлэлтийн ажлын тайланг сар бүр гарган Иргэний нисэхийн ерөнхий газрын даргад тайлагнаж чиглэл авч ажиллахыг гэрчилгээжүүлэх багийн ахлагч /С.Ерханат/-д, гэрчилгээжүүлэлтийн багийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн дэмжин ажиллахыг Нисэх буудлуудын бодлого зохицуулалтын хэлтэс /Д.Эрдэнэбаатар/, Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Ё.Эрдэнэбат/-т нарт тус тус үүрэг болгосугай.



Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2018 оны 05 дугаар сарын 11 -ны өдрийн
0252 дугаар тушаалын хавсралт



ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч:	С.Ерханат	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Х.Ариунаа	“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Үйлдвэрлэлийн төлөвлөлт, зохицуулалт, хяналтын хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	П.Ганбаатар	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн ахлах байцаагч
	Х.Эвсанаа	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Нислэгийн стандарт, үйл ажиллагааны хяналтын хэлтсийн ахлах байцаагч
	Б.Анхбаяр	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн аюулгүй байдлын ахлах байцаагч
	Н.Энхбат	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн байцаагч
	Д.Дэлгэрсайхан	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн байцаагч
	Д.Маасүрэн	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн байцаагч
	Я.Уртнасан	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аэродром агаарын навигацийн хяналтын хэлтсийн байцаагч

Б.Хатанбүүвэйбаатар	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Нислэгийн стандарт, үйл ажиллагааны хяналтын хэлтсийн байцаагч
Ч.Уранчимэг	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Нислэгт тэнцэх чадварын хэлтсийн байцаагч
Гэрээт байцаагч	Авран хамгаалах, галын унтраах ажиллагаа хариуцсан
Гадаадын эксперт /тохиролцсоноор/	ИКАО-ын Cooperative Development of Operational Safety and Continuing Airworthiness Programme /COSCAP-N, Cooperative Aviation Security Programme /CASP/